Цэцэрлэг	43,074.3	54,999.1	11,924.8	13.1
Орон нутгийн хөгжлийн сан	3,500.0	3,500.0	-	0.8
НИЙТ ДҮН	272,346.1	420,688.2	148,342.1	100.0

Эх сурвалж: Жаргалант сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 567,145.3 мянган төгрөгийн бараа материалын 413,522.1 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 35853.3 мянган төгрөгийн

материал хандиваар хүлээн авч, 117,769.8 мянган төгрөгийн материалыг бусад байгууллагаас болон дотоод шилжүүлгээр шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	567,145.3	Хасагдсан	826,319.0
Худалдан авсан	413,522.1	Худалдсан, зарцуулсан	405,630.8
Хандиваар	35,853.3	Шилжүүлсэн	-
Шилжүүлэн авсан	25.0		
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	54,743.3	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	-
Бусад	63,001.6	Бусад	420,688.2

Эх сурвалж: Жаргалант сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,269,683.5 мянга, эцсийн үлдэгдэл 7,550,376.0 мянган төгрөг болж, 1,280,692.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	6,135,187.5	7,400,639.0	1,265,451.5	98.0
Барилга байгууламж, орон сууц	4,638,886.6	5,447,030.4	808,143.8	72.1
Тээврийн хэрэгсэл	206,120.8	224,470.8	18,350.0	3.0
Машин тоног төхөөрөмж	417,039.9	809,823.5	392,783.6	10.7
Тавилга эд хогшил	216,499.9	259,431.9	42,932.0	3.4
Зам гүүрийн байгууламж	194,620.0	194,620.0	-	2.6
Түүх соёлын дурсгалт зүйл	1,800.0	1,800.0	-	0.0
Номын фонд	56,564.7	59,806.9	3,242.2	0.8
Бусад үндсэн хөрөнгө	403,655.5	403,655.5	-	5.3
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	134,496.0	149,737.0	15,241.0	2.0
Программ хангамж	980.0	2,915.0	1,935.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	133,516.0	146,822.0	13,306.0	1.9
НИЙТ ДҮН	6,269,683.5	7,550,376.0	1,280,692.5	100.0

Эх сурвалж: Жаргалант сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө 1,280,692.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнд Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан нь сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын тамгын газар	1,884,936.5	1,914,151.3	29,214.8	25.4
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	14,124.9	14,124.9	-	0.2
Соёлын төв	2,209,579.1	2,220,398.6	10,819.5	29.4
Эмнэлэг	-	1,197,317.0	1,197,317.0	15.9
Сургууль	1,753,380.4	1,790,957.0	37,576.7	23.7
Цэцэрлэг	407,662.7	413,427.3	5,764.6	5.5
НИЙТ ДҮН	6,269,683.5	7,550,376.0	1,280,692.5	100.0

Эх сурвалж: Жаргалант сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 1,313,182.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нь Засаг даргын Тамгын газар 61,844.5 мянга, сургууль 15,623.8 мянга, соёлын төв 8,897.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч эрүүл мэндийн төвийн 1,177,473.6 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	1,363,470.6	Хасагдсан	82,778.0
Худалдан авсан	50,288.3	Худалдсан	-
Хандиваар	64,967.2	Акталсан	53,043.0
Шилжүүлэн авсан	61,844.5	Шилжүүлсэн	29,735.0
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	1,177,473.6		
Бусад	8,897.0	Бусад	-

Эх сурвалж: Жаргалант сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 546.1 мянга, эцсийн үлдэгдэл 45,667.8 мянган төгрөг болж 45,121.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	546.1	45,667.8	45,121.7	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	543.1	457.3	(85.8)	1.0
Байгууллагад төлөх өглөг	-	43,410.7	43,410.7	95.1
Хувь хүмүүст төлөх өглөг	3.1	1,469.1	1,466.0	3.2
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	-	330.7	330.7	0.7
Дүн	546.1	45,667.8	45,121.7	100.0

Эх сурвалж: Жаргалант сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 457.3 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой, 43,410.7 мянган төгрөгийн байгууллагад төлөх, 1,469.1 мянган төгрөгийн хувь хүмүүст төлөх, 330.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг байгаа ба эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 43,390.0 мянган төгрөгийн байгууллагад төлөх, 1,460.0 мянган төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг үүссэн нь гол нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХурал	3.1	29.9	26.8	0.1
ЗДТГазар	43.1	-	(43.1)	-
Соёлын төв	73.3	61.5	(11.8)	0.1
Эрүүл мэндийн төв	-	44,849.9	44,849.9	98.2
Сургууль	30.8	330.7	299.9	0.7
Цэцэрлэг	395.8	395.8	-	0.9
НИЙТ ДҮН	546.1	45,667.8	45,121.7	100.0

Эх сурвалж: Жаргалант сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,560,865.7 мянга, эцсийн үлдэгдэл 6,744,894.3 мянган төгрөг болж, 1,184,028.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,251,076.5	1,856,356.2	605,279.6	27.5
Өмч: - төрийн	1,251,076.5	1,856,356.2	605,279.6	27.5
Хуримтлагдсан үр дүн	613,690.3	834,077.7	220,387.4	12.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,696,098.8	4,054,460.4	358,361.6	60.1
Дүн	5,560,865.7	6,744,894.3	1,184,028.7	100.0

Эх сурвалж: Жаргалант сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6,744,894.3 мянган төгрөг болж 1,184,028.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн 220,387.4 мянган төгрөгийн өсөлт, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнтэй холбоотой 358,361.6 мянган төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, 605,279.6 мянган төгрөгийн төрийн өмчийг нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.18-ны өдрийн хуралдааны 2/12 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 64,900.0 мянга, хүү торгуулийн орлогыг 7,500.0 мянга, нийт 72,400.0 мянган төгрөгөөр анх баталсан ба сумын ИТХ-ын 2021.10.15-ны өдрийн 4/05 дугаар тогтоолоор ан агнуур ашигласны төлбөрийн орлогыг 33,600.0 нэмж нийт сумд төвлөрөх татварын болон татварын бус орлогыг 106,000.0 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	98,500.0	261,384.9	162,884.9	265.4
1.1.ИОТХ	16,000.0	22,038.8	6,038.8	137.7
1.2.Хадгаламжийн хүүгийн орлого	27,000.0	47,287.0	20,287.0	175.1
1.3.Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	3,000.0	10,258.2	7,258.2	341.9
1.4.Бууны татвар	6,500.0	6,600.0	100.0	101.5
1.5.Улсын тэмдэгийн хураамж	1,500.0	1,657.6	157.6	110.5
1.6. Газрын төлбөр	1,400.0	1,137.2	(262.8)	81.2
1.7.Ан агнуурын нөөц ашигласны төлбөр	33,600.0	164,164.4	130,564.4	488.6
1.8. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	9,000.0	7,847.2	(1,152.8)	87.2
1.9. ТТАМАТөлбөр	500.0	394.5	(105.5)	78.9
2.Татварын бус орлого	7,500.0	7,313.4	(186.6)	97.5
2.1.Хүү торгуулийн орлого	7,500.0	7,313.4	(186.6)	97.5
Нийт дүн	106,000.0	268,698.3	162,698.3	253.5

Сумын төсөвт төвлөрөх нийт орлогыг 162,698.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байгаа ба үүнд ИОТХ 6,038.8 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 20,287.0 мянга, үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар 7,258.2 мянга, ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн 130,564.4 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь гол нөлөөг үзүүлж байна.

Харин хог хаягдлын үйлчилгээний төлбөрийн орлого, үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны газрын төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хүү торгуулийн орлогын төлөвлөгөө тус тус биелээгүй тасарсан байна.

3.5.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2,929,075.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,704,553.8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2,558,158.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 146,395.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020.12.18-ний өдрийн 02/12 дугаар тогтоолоор нийт 2,789,287.8 мянган төгрөгийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ны өдрийн 2/12 дугаар тогтоолоор анх 2,789,287.8 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.09-ний өдрийн 3/03 дугаар тогтоолоор 10,017.4 мянга, 2021.10.15-ны өдрийн 4/05 дугаар тогтоолоор 90,971.2 мянган төгрөгөөр нэмж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 38,800.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 2,929,075.9 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1,744,810.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 101,487.2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 656,643.9 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 106,000.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 155,319.1 мянган төгрөгийг үндсэн болон туслах

үйл ажиллагааны орлогоос, 28,824.3 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 135,991.8 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг бүрэн авч, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 3,439.4 мянган төгрөгөөр дутуу авсан ба улсын төсөвт 44,454.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улс	ОН
Засаг даргын Тамгын газар	445,707.9	431,947.1	13,760.8	96.9	-	9,464.9
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	77,615.7	68,150.8	9,464.9	87.8	-	14,116.6
Соёлын төв	99,959.8	99,246.4	713.4	99.3	-	713.4
Эрүүл мэндийн төв	538,938.0	535,393.6	3,544.4	99.3	0.3	-
Сум хөгжүүлэх сан	198,674.6	56,885.0	141,789.6	28.6	-	-
Сургууль	1,062,955.0	1,042,290.7	20,664.4	98.1	19,777.3	-
Цэцэрлэг	349,922.9	324,245.3	25,677.7	92.7	24,676.7	-
Орон нутгийн хөгжлийн сан	155,302.0	146,395.0	8,907.0	94.3	-	-
Нийт дүн	2,929,075.9	2,704,553.8	224,522.1	92.3	44,454.3	24,294.9

Эх сурвалж: Жаргалант сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь ЗДТГ-ын төсвийг 13,760.8 мянга, ИТХ-ын төсвийг 9,464.9 мянга, Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 20,664.4 мянга, сургуулийн өмнөх боловсролын зардлыг 25,677.7 мянга, Эрүүл мэндийн төвийн төсвийг 3,544.4 мянган төгрөгөөр хэмнэж, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 8,907.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлэн, сум хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг Эргэн төлөлтийн орлого хангалтгүйгээс 140,000.0 мянган төгрөгөөр дутуу олгосон нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 124,081.9 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоор 39,992.7 мянга, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 48,657.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 24,318.4 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 21,737.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 109,370.3 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид 24,318.5 мянга, хөрөнгийн зардалд 5,867.5 мянган төгрөгийг зарцуулж 17,263.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	Соёл	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	1,000.0	35,224.3	41,838.6	21,669.0	245,872.9	350.0	345,954.9
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.0	14,160.7	35,797.0	21,669.0	74,767.9	-	147,394.6
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	21,063.7	6,041.7	-	-	350.0	27,455.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	-	-	-	171,105.0	-	171,105.0
НИЙТ ЗАРЛАГА	1,000.0	24,972.5	41,837.6	21,669.0	245,872.9	350.0	335,702.0

Жаргалант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000.0	24,972.5	10,615.8	-	210,293.9	350.0	247,232.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,000.0	24,972.5	10,615.8	-	210,293.9	350.0	247,232.2
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	10,251.9	31,222.8	21,669.0	35,579.0	-	98,722.7
Төсөвт төвлөрүүлсэн	-	10,251.9	1.0	-	-	-	10,252.9

Эх сурвалж: Жаргалант сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын засаг даргын нөөц санд 34,270.0 мянга, гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгааны зардалд 22,210.0 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 52,776.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Жаргалант сумыг 2021 онд хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 8 үндсэн зорилтын хүрээнд 116 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 88.0 хувийн гүйцэтгэлтэй, Жаргалант сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 80.5 хувийн биелэлттэй гэж тайлагнажээ.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Жаргалант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Жаргалант сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЕБСургууль	1	1	1		1	1			
Хүүхдийн цэцэрлэг	1	1	1		1	1			
ЗДТГ	1	1	1		1	1			
ИТХурал	1	1		1					
Соёлын төв	1	1		1					
ЭМТ	1	1	1		1	1			
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					

НИЙТ ДҮН	8	8	4	4	4	4	0	0	0
-----------------	----------	----------	----------	----------	----------	----------	----------	----------	----------

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 688,272.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 23,406.1 мянган төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулж, 889.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 3,847.2 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 660,130.1 мянган төгрөгийн 10 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Залруулга		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
					Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
а.Санхүүгийн тайлангийн зөрчил	11	33,489.4	4	23,406.1	2	889.2	1	3,847.2	4	5,346.9
Засаг даргын Тамгын газар	4	7,192.2			1	810.0	1	3,847.2	2	2,535.0
Ерөнхий боловсролын сургууль	2	12,711.3	1	12,632.1	1	79.2				
Соёлын төв	4	11,564.8	3	10,774.0					1	790.8
Орон нутаг хөгжлийн сан	1	2,021.1							1	2,021.1
а.СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал	8	654,783.2	0	-	0	-	2	-	6	654,783.2
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	-					1	-		
Засаг даргын Тамгын газар	1	413,326.5							1	413,326.5
Ерөнхий боловсролын сургууль	2	71,809.6							2	71,809.6
Цэцэрлэг	2	104,827.1							2	104,827.1
Соёлын төв	1	-					1	-		
Орон нутаг хөгжлийн сан	1	64,820.0							1	64,820.0
Нийт зөрчлийн дүн	19	688,272.6	4	23,406.1	2	889.2	3	3,847.2	10	660,130.1

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 33,489.4 мянган төгрөгийн 11 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 654,783.2 мянган төгрөгийн 8 зөрчил тус тус илэрсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд

хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих 2,321,581.0 мянган төгрөгийн 151 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг Жаргалант сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад нийт 5 байгууллагад алдаа, зөрчил илэрч алдаа, зөрчлийн давтан гаргуулахгүй байх 62,275.3 мянган төгрөгийн 6 зөвлөмжийг төсвийн захирагч нарт хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 228,363.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 130,164.8 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж залруулж, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, 98,198.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд ЭМД-аас авах санхүүжилтийн 341,280.0 мянган төгрөгийн авлага, 44,849.9 мянган төгрөгийн өглөг үүссэн ба цаашид өглөг авлагын тооцоог тухайн онд нь багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Жаргалант сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 239,710.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 197,832.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгч, 41,877.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлж байна.

4.1 Албан шаардлага

Сум хөгжүүлэх сангийн 197,832,170 төгрөгийн зээлийн авлагын үлдэгдлийг зээлдэгч нэг бүрээр баталгаажуулаагүй, сангийн тайланг зөрүүтэй бэлтгэсэн байхад Санхүүгийн алба хяналт хийлгүй Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сум хөгжүүлэх сангийн үлдэгдлийн судалгааг зээлдэгч бүрээр үнэн зөв гарган авлагын үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлага өгөв.

4.2 Зөвлөмж

1. Тус сумын ОНЕО-ын дансанд сумд төвлөрөх татварын болон бус орлогоор 268,698.3 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 265,620.4 мянган төгрөг буюу 3,077.9 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид орон нутгийн дансанд төвлөрсөн орлогын тайлан мэдээг Татварын хэлтэст үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгөв.

2. Тус сумын Засаг даргын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалттай нийцүүлэн тайлагнаж байх, мөн хуулийн 64.1.3-т заасны дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлж батлуулж байх зөвлөмж өгөв.

3. Аймгийн Засаг даргын 2021 оны А/742 дугаар захирамжаар тус сумын Ерөнхий боловсролын сургуульд олгох тусгай зориулалтын шилжүүлгээс олгох санхүүжилтийг 38,800.0 мянган төгрөгөөр нэмсэн байхад сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгоогүй төсвийн гүйцэтгэлийн тайлан сумын ИТХ-ын тогтоолоос 38,800.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх “дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 07 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Жаргалант сумын ТТЗ		4	239,710.1					1	197,832.2	3	41,877.9
Дүн		4	239,710.1					1	197,832.2	3	41,877.9

6. Хавсралт 1.: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Жаргалант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:		
2021			БНА-2022/3/НА-СТА-ТТЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Жаргалант сумын Засаг дарга	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Тус сумд тусгай зориулалтын шилжүүлгээс олгох санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2021 оны А/742 дугаар захирамжаар ЕБС-ийн санхүүжилтийг 38800.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байхад сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгоогүй төсвийн гүйцэтгэлийн тайлан сумын ИТХ-ын тогтоолоос 38800.0 мянган төгрөгөөр илүү байна.	38,800.0	Зөвлөмж өгсөн.	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Мөнхжаргал, Д.Азжаргал
2	Тус сумын ОНХО-ын дансанд сумд төвлөрөх татварын болон татварын бус орлогоор 268698.3 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 265620.4 мянган төгрөг буюу 3077.9 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.	3,077.9	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Мөнхжаргал, Д.Азжаргал
3	Тус сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд 197,832.2 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага байгаа боловч зээлийн үлдэгдлийн судалгааг нягтлан бодогч зээлдэгч нэг бүрээр үнэн зөв гаргаж авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	197,832.2	Албан шаардлага өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Мөнхжаргал, Д.Азжаргал
4	Тус сумын Засаг даргын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу гаргаагүй байна.		Зөвлөмж өгсөн.	Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Мөнхжаргал, Д.Азжаргал
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дүн		239,710.1			
Харьяа төсвийн байгууллагуудын дүн		686,517.6			
Сургууль		84,520.9			
1	Тайлант оны санхүүгийн тайлангаар бараа материалын 35110 данс буюу тусгай зориулалтын дансны үлдэгдэл 7,826.9 мянга, 35470 данс буюу түрээсийн сурах бичгийн дансны үлдэгдэл 4,805.1 мянган төгрөг байхад Э-тайланд 2 дансны үлдэгдлийг зөрүүлж шивсэн байна.	12,632.1	санхүүгийн тайланд залруулсан.	Захирал, Нягтлан бодогч	Б.Саранцэцэг, Б.Өлзийбуян
2	Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Дугаар 131/ШШ2021/00277 дугаар бүхий захирамжийн дагуу тус сургуулийн технологийн багш ажилтай Б.Санжсүрэн, сургуулийн захирал Б.Саранцэцэг нартай холбоотой тэмдэгтийн хураамж 35.1 мянга, ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэл 44.1 мянган төгрөг нийт 79.2 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс гаргасан байна.	79.2	Төлбөрийн акт тогтоосон.	Захирал, Нягтлан бодогч	Б.Саранцэцэг, Б.Өлзийбуян
3	Шилэн дансны цахим сайтад нийт 1,103,906.6 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас 1,090,733.6 мянган төгрөгийн 116 мэдээлэл оруулсан бөгөөд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 52,071.9 мянган төгрөгийн орлого,	52,071.9	Зөвлөмж өгсөн.	Захирал, Нягтлан бодогч	Б.Саранцэцэг, Б.Өлзийбуян

Жаргалант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	зарлагын мөнгөн гүйлгээ болон нийт 33 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.				
4	Тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 103,123.0 мянган төгрөгөөр баталж 102,236.0 мянган төгрөгийг зарцуулж, нийт 20,624.6 мянган төгрөг хэмнэхээс 19,737.6 мянган төгрөгийг хэмнээгүй байна.	19,737.7	Зөвлөмж өгсөн.	Захирал, Нягтлан бодогч	Б.Саранцэцэг, Б.Өлзийбуян
Засаг даргын Тамгын газар		420,518.7			
5	Сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Саранцэцэгийг Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны 2021.01.27-ны өдрийн 111/ШШ2021/0004 шүүхийн шийдвэрээр ажилд эргүүлж томилж ажилгүй байсан хугацааны цалинг олгох шийдвэр гарсны дагуу 2021.08.03-ны өдөр нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 3516.5 мянга, 2020 оны 9-12 сарын НДШ-д 330.7 мянга нийт 3,847.2 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.	3,847.2	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Б.Өнөрбаяр Д.Баттөр
6	ЗДТГ-ын босоо удирдлагатай нийгмийн даатгалын байцаагч, татварын байцаагч, байгаль хамгаалагч нарт 2021 оны эхний хагас жилийн үр дүн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг харгалзан сумын ЗДТГ-ын даргын 2021.08.02-ны өдрийн А/25 дугаар тушаалаар нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 810.0 мянган төгрөгийг олгож зориулалт бусаар зарцуулсан байна.	810.0	Төлбөрийн акт тогтоосон.	Дарга, нягтлан бодогч	Б.Өнөрбаяр Д.Баттөр
7	Тус байгууллага нь 2021 онд нийт 493,474.0 мянган төгрөгийн 151 мэдээллээс 1 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 24 гүйлгээний 376,041.4 мянга, зарлагын 2 гүйлгээний 37,285.1 төгрөгийг мэдээлээгүй байна	413,326.5	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Б.Өнөрбаяр Д.Баттөр
8	Сумын Засаг даргын А/130 дугаар захирамжаар Монгол орны үзэсгэлэнт байгаль, түүхэн дурсгалт төслийн хүрээнд зураг авалт, баримтат кино хийх хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 2021.09.29-нд "Титанс Пикчерс" ХХК-д 2,535.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан байна.	2,535.0	Зөвлөмж өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Б.Өнөрбаяр Д.Баттөр
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал		0			
9	Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 26370.8 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас 4-р улирлын төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, 5 сая төгрөгөөс дээш үнийн бүхий орлогын 26370.8 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.	0	Албан шаардлага өгсөн.	Дарга, нягтлан бодогч	Д.Уранчимэг Д.Баттөр
Цэцэрлэг		103,072.1			
10	Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлэл зохих 149 мэдээллээс нийт 103072.1 мянган төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	103,072.1	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч, нягтлан бодогч	Д.Түмэнжаргал, Б.Өлзийбуян
Орон нутгийн хөгжлийн сан		66,841.1			
11	Тайлант хугацааны ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас авах санхүүжилт 101487.2 мянга, урьд оны үлдэгдлээс 26359.5 мянга, орон нутгийн төсвөөс 10000.0 мянга, өвс тэжээлийн орлогоор 17455.3 мянган төгрөгийг тус тус бүрдүүлж зарцуулахаар баталсан ба тайлант хугацаанд өвс тэжээлийн давсан орлого 2021.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.	2,021.1	Зөвлөмж өгсөн.	Засаг дарга, Нягтлан бодогч	Д.Мөнхжаргал, Д.Доржпагма
12	Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 т заасан 64820.0 мянган төгрөгийн 4 мэдээллийг хоцроосон	64,820.0	Зөвлөмж өгсөн.	Засаг дарга, Нягтлан бодогч	Д.Мөнхжаргал, Д.Доржпагма
Соёлын төв		11,564.8			
13	Тайлант хугацаанд харилцах дансаар хийгдсэн 4617.0 мянган төгрөгийн халаалтын зардал, нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар хийгдсэн 230.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг нягтлан бодох	4,847.0	3-р улирлын санхүүгийн	Эрхлэгч, нягтлан бодогч	Ц.Туул, Д.Доржпагма

Жаргалант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	бүртгэлд бүртгээгүйгээс санхүүгийн программ дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.байна.		тайланд залруулсан		
14	Тайлант хугацааны мөнгөн гүйлгээний журналыг тулгахад 319.9 мянган төгрөгийн 13 гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, мөн ном хэвлэлийн зардлаас бичиг хэрэгт 100.6 мянга, гэрэл цахилгааны зардлаас материалын үнэнд 104.7 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан, төлбөрийн нэхэмжлэх дээрх хүлээн авагчийн нэр зөрүүтэй байхад 265.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг хийсэн байна.	790.8	Зөвлөмж өгсөн.	Эрхлэгч, нягтлан бодогч	Ц.Туул, Д.Доржпагма
15	Тус байгууллагын урсгал засварын зардлаас худалдан авсан 780.0 мянган төгрөгийн өртөг бүхий хашааны хайс, 140.0 мянган төгрөгийн өртөг бүхий төмөр шонг аж ахуйн материалд бүртгэсэн байна.	920.0	3-р улирлын санхүүгийн тайланд залруулсан	Эрхлэгч, нягтлан бодогч	Ц.Туул, Д.Доржпагма
16	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 4 дүгээр улирал, 6.1.4-д заасан санхүүгийн тайлан /хагас, бүтэн жилээр/, 6.4.4-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 34,627.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, 6.4.5-д заасан орлогын 99,959.8 мянган төгрөгийн 12 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	-	Албан шаардлага өгсөн.	Эрхлэгч, нягтлан бодогч	Ц.Туул, Д.Доржпагма
17	Тайлант хугацааны цалингийн зардлыг 318.4 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн, нийгмийн даатгалын шимтгэлийг 37.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, мөн түлш халаалтын өглөгийг 4617.0 мянган төгрөгөөр илүү, гэрэл цахилгааны өглөгийг 34.6 мянган төгрөгөөр дутуу тусгасан.	5,007.0	санхүүгийн тайланд залруулсан.	Эрхлэгч, нягтлан бодогч	Ц.Туул, Д.Доржпагма

оОо